

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/015/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Д.Даариймаа Утас: 70342495 Цахим хаяг: daariimaado@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдугчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

8015.06.02 № 22

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРЦЭНГЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 11.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

006020053

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд аймгийн худалдан авах ажиллагааны газар орон нутгийн өмчийн газраас тээврийн хэрэгсэл 2.0, машин тоног төхөөрөмж 15.0, тавилга эд хогшил 5.2, програм хангамж 3.7 нийт 22.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 зорилт 38 арга хэмжээний хэрэгжилт 99.1 хувиар дүгнэсэн, хөтөлбөр арга хэмжээнд зориулан 235.2 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 97.9 хувийг зарцуулсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЖЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	4,920,890.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	28,329,579.22
	Нийт хөрөнгийн дүн	-	33,250,469.22
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	33,250,469.22
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	33,250,469.22
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	-	32,206,538.82
	Үйл ажиллагааны зардлын дүн	-	227,824,936.00
	Үйл ажиллагааны үр дүн	-	(195,618,397.18)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	333,333.60
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	(195,951,730.78)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		0
	Тайлант оны үр дүн		33,250,469.22
	Эцсийн үлдэгдэл		33,250,469.22
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	240,612,200.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	222,582,200.00
	Үйл ажиллагааны ЦМГ	-	222,582,200.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(18,030,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	(18,030,000.00)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		(18,030,000.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		699,773,005.46
	Урсгал зардал		713,191,723.46
	Хөрөнгийн зардал		0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		243,000.00
	Улсын төсвөөс санхүүжих		43,400.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	52,269,194.00

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн акт, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын тэргүүлэх чиглэл, эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд , дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх, ил тод, нээлттэй тендер шалгаруулалтын бодлого баримтлан ажиллахад оршино

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 онд үүсгэн байгуулагдсан жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийг 33,250.5 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Төсвийн төлөвлөлт

Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 432,300.0 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлснийг 197,097.8 мянган төгрөгөөр бууруулан 235,202.2 мянган төгрөг болгон баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,339,408.8 мянган төгрөгийг улсын төсвөөс олгож, гүйцэтгэлээр 1,331,155.2 мянган төгрөг буюу төсвийн 99.4 хувь зарцуулж 8,253.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулиар цахим хуудсанд мэдээлэхээр заасан мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 229,202.2, зарлагын 4 гүйлгээний 24,505.2 мянган мэдээллийг байршуулж мөн өмч хөрөнгөтэй холбоотой 5 тушаал шийдвэр мэдээлсэн байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 786,871.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 786,871.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоон ажиллаа.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 3 албан хаагчид таван жилийн тэтгэмжийг тооцон олгохдоо 4 дүгээр сарын цалинг дотоод журамд заасан хугацаанаас өмнө олгож тэр сарын цалинг нийлүүлж тооцож 786.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

5.2 Албан шаардлага

Байхгүй

5.3 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
таван жилийн тэтгэмжийг тооцон олгохдоо 4 дүгээр сарын цалинг дотоод журамд заасан хугацаанаас өмнө олгож тэр сарын цалинг нийлүүлж тооцсон	1	786.9	1	786.9								
Дүн	1	786.9	1	786.9								